

## ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Төслийн ерөнхий мэдээлэл


<b>Төслийн нэр:</b>	“Хайлуур жонш” баяжуулах үйлдвэр “Монголжуюаньли” ХХК	
<b>Төсөл</b>	Хаяг: Улаанбаатар хот, 3-р хороо, Тээвэрчдын гудамж 5 тоот	
<b>хэрэгжүүлэгч:</b>	Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас баруун зүгт 15 км-т байрлана.	
<b>Төсөл</b>	Талбайн солбицлууд:	
<b>хэрэгжүүлэх</b>	1. 112° 09' 27.02"	47° 33' 06.79"
<b>үйлдвэрийн</b>	2. 112° 08' 42.02"	47° 33' 06.79"
<b>байршил:</b>	3. 112° 08' 42.02"	47° 33' 41.78"
	4. 112° 09' 27.02"	47° 33' 41.78"
<b>Төсөл</b>	Улсын бүртгэлийн гэрчилгээ	
<b>хэрэгжүүлэгч</b>	Улсын бүртгэлийн дугаар: 9019018095	
<b>байгууллагын</b>	Улсын регистрийн дугаар: 5051304	
<b>хууль эрх зүйн</b>	Улсад бүртгүүлсэн: 2006-03-23	
<b>хүчинтэй</b>	“Хайлуур жонш” хайлуур жоншны ордын нөөц хүлээн авсан	
<b>баримтуудын</b>	АМГ-ын даргын тушаал,	
<b>жагсаалт:</b>	Дугаар: №84	
	Он сар: 2009-04-06	
<b>Төсөл</b>	ЭБМЗ-ийн дүгнэлт	
<b>хэрэгжүүлэгч</b>	Дугаар: 01-11	
<b>баримтуудын</b>	Он сар: 2009-03-26	
<b>жагсаалт:</b>	ТЭЗҮ хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт	
	Дугаар: T-21-04-05	
	Он сар: 2024-04-01	
	ТЭЗҮ хүлээн авсан АМГ-ын даргын тушаал	
	Дугаар: T/77	
	Он сар: 2024-05-04	
	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл	
	Дугаар: MV-010988	
	Олгосон: 2007-01-29	
	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлийн хүчинтэй	
	хугацаа	
	Он сар: 2037-01-29	

## БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Түмэнцогтын хайлуур жоншны баяжуулах үйлдвэр болон MV-010988 тусгай зөвшөөрөл бүхий орд нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт, сумын төвөөс баруун зүгт 15 км зайд байрладаг ба ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь 101 га болно.

Ордын солбицол нь:

- |                    |                |
|--------------------|----------------|
| 1. 112° 09' 27.02" | 47° 33' 06.79" |
| 2. 112° 08' 42.02" | 47° 33' 06.79" |
| 3. 112° 08' 42.02" | 47° 33' 41.78" |
| 4. 112° 09' 27.02" | 47° 33' 41.78" |



Зураг-1.1 “Монголжууаньли”-ийн баяжуулах үйлдвэрийн газарзүйн байршил

**Байгаль орчны болон нийгэм эдийн засгийн гол нөлөөллүүдийн хураангуй Газрын гадарга**

Жонш баяжуулах үйлдвэр байрлах “Хайлуур жонш” орд нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт харьялагдах ба Улаанбаатар хотоос зүүн урагш 420 км, Өндөрхаан хотоос 125 км, Чойбалсан хотоос 180 км-т Бэрх-Түмэнцогтын хүдрийн

зангилаанд оршдог ба эдийн засгийн зүүн бүсэд багтана. Газарзүйн байршилын хувьд Хэнтийн нурууны зүүн хойд төгсгөлд хамарагдана.

Талбайн район д ахь хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1358 м өндөрт өргөгдсөн Түмэнцогт уул ба хамгийн нам цэг нь 1050 м өндөрт өргөгдсөн Талын шандын хөндий, Хэрлэн голын хөндий юм. Төвийн болон хойд хэсгүүдээрээ далайн түвшнээс дээш 1100-1200 м өргөгдсөн жижиг толгодлог гадаргуу зонхилох ба гадаргуу нь хадан гарштай жижиг дэлүүд дийлэнхи хэсгийг эзэлнэ.

Нутаг дэвсгэрийн баруун урд хэсэгт толгодлог алсаас налуу толгод, тэгш тал газрын байдалд аажмаар шилжсэн гадаргуугийн үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 1000-1100 м хүртэл намссан гадаргуу зонхилно.

### Цаг уур

Нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтана. Ажиглалтаас үзэхэд сар, хоногийн температур нь эрс хэлбэлздэг. Хур тунадас бага, агаарын чийгшилт харьцангүй бага хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард  $-12^{\circ}\text{C}$ - $25^{\circ}\text{C}$ , хур тунадас бага унадаг ба жилд дунджаар 160-180 мм хүрнэ.

Эх газрын баруун хойноосоо чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2.8-7.3 м/сек хэлбэлзэлтэй байдаг. Хаврын улиралд 10-12 м/сек байдаг ба сүүлийн жилүүдэд хааяа 15-18 м/сек хүртэл хурдаач шороон ба цасан шуурга шуурч, хүчтэй салхилдаг болсон.

Жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас орон нутгийн уур амьсгалыг өөрчлөх сөрөг нөлөөлөл үүсэхээргүй байна. Харин энэ төсөл нь Монгол орны уур амьсгалын эрс тэс нөлөөллийн дор хэрэгжих тул олборлолтын үед цаг агаар, уур амьсгалын нөхцөл ихээхэн нөлөөтэй байх болно.

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас орон нутгийн уур амьсгалыг өөрчлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна. Төсөл хэрэгжих явцад тоосжилт үүсэх зэргээр бохирдуулагч бодисын тоо хэмжээ нэмэгдэх ч стандарт хэмжээнээс давж, бохирдуулах хэмжээнд хүрч үйлчлэхгүй тул орон нутгийн уур амьсгалыг өөрчлөгч хүчин зүйл болж чадахгүй.

### Агаарын чанар

Үйлдвэр орчмын нутаг дэвсгэрийн хөрс эвдэгдэн тоосрох, хүнд даацын автомашины хөдөлгөөн, автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал нь агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг ихэсгэнэ. Нөлөөллийн эрчмийн хувьд технологийн үе шатуудад дунд зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна.

Баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангаас үүсэх тоосжилт, уг ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслээс гарах утаа зэрэг эх үүсвэрүүдээс тоосжилт, агаарын бохирдол үүснэ.

### Гадаргын болон гүний ус

Талбайн хэмжээнд гидрогеологийн нөхцөл муутай, усжилтаар сулхан бүс нутагт хамарагдах бөгөөд.govийн халуун хуурай цаг ууртай. Гүний ус төдийлөн элбэг биш. Гүний усны тэжээгч нь агаарын чийгшилт, хур тунадасны буултаас хамаардаг.

### Хөрс

Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн хөрс зонхилох ба голдуу элсэнцэр, шавранцар

агуулагч хужирлаг цайвар шаргал хөрс нь аллювиаль нуурын гаралтай шавранцараас тогтоно. Хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2 м, хааяа 30-40 см хүртэл хэлбэлзэнэ.

Үйлдвэр орчмын хөрс нь авто машины болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө. Хуурай хог хаягдлаар орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх зэргээр нөлөөлнө. Тээвэрлэлтээс хөрсний бүтэц эвдрэх, газрын гадарга, хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалыар бохирдож болзошгүй.

#### Ургамлан нөмрөг

Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялган, хазаар, агь таана, хөмүүл, шарилж зэрэг болно.

#### Амьтны аймаг

Судлагдсан дүүрэг нь ан амьтнаар нэлээд баялаг. Махчин амьтдаас үнэг, хярс, дорго, мануул, чоно, мэрэгчдээс тарвага, үлийн цагаан оготно, олби, орог саарал, шар сүүлт, алаг даахай, туулай зэргийг нэрлэж болно.

Дулааны улиралд тогоруу, галуу, тоодог, турлиах нүүдэллэн ирдэг ба уул нутагт байнга оршин байдаг шувуудаас бүргэд, элээ, харцага, хэрээ, шар шувуу, болжмор, ногтруу, тагтаа, ууль зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, хонин ба могой гүрвэл зэрэг байдаг.

#### Нийгэмд нөлөөлөх байдал

Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг, харин баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны үед үүсэх машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, малын бэлчээр хумигдах зэргээр нөлөөлж болзошгүй.

#### Түүх соёлын дурсгалт зүйлс

Төсөл хэрэгжих орчны газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс одоогоор илрээгүй байгаа бөгөөд хэрвээ илэрвэл тэр даруйд холбогдох байгууллагад мэдээллэх үүрэгтэй.

#### Эрсдлийн үнэлгээ

Эрсдлийн үнэлгээ нь төлөвлөгдөөгүй үйл явдлуудын нелөөллүүдийг магадлал болон үр дагавруудын эрчмийн хувьд авч үзэхийг зорьдог. Үр дагаврууд нь нөлөөлөлд өртөх хүмүүст өрөнхийдөө амь нас, гэмтэл, өвчлөл зэргээр, харин орчинд сөрөг нөлөө хэлбэрээр илэрнэ. Уурхайн үйл ажиллагаатай холбоотой гэнэтийн эрсдлүүд нь ашиглалтын үед үүсч болзошгүй аюул осолтой холбоотой эрсдлүүд юм. Төлөвлөсөн бүх хяналт менежментийн арга хэмжээнүүд, хөдөлмөр хамгааллыг чанд хэрэгжүүлсэн тохиолдолд онцгой сөрөг нөлөө байхгүй.

#### Арга хэмжээнүүдийн хураангуй

#### Агаарын чанар

Сөрөг нөлөөллийг бууруулахын тулд уурхай орчмын тоосжилтын нөлөөг багасгах нь чухал арга хэмжээ гэдгийг онцгой анхаарч хэрэгжүүлэх, тоосжилтын эх үүсвэрүүдийг услах, машины хурдыг хязгаарлах, шатах тослох материалыг асгарч алдагдахаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсад мөрдөгдөж буй утаа болон бохирдлын стандартууд, олон улсын холбогдох

стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлэх, тээврийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй түлш, шатахуунд Монгол улсад мөрдөгдөж буй бохирдлын стандартууд болон олон улсын зохих стандартуудыг дагаж мөрдөх, уурхайд ашиглагдах техник хэрэгслүүдийг засвар үйлчилгээнд хамруулж хорт хийн ялгарлыг багасгах арга хэмжээ авч байх, мөн тээврийн хэрэгслийг засаж, сайжруулж түлшний үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлэх зэрэг болно.

#### *Гадаргын болон гүний ус*

Газрын доорх ус буюу ундны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна. Нөгөө талаар бороо хурын ус чийг, хөрсөнд бий болсон дээрх бохирдлуудыг цааш дамжихад ихээхэн нөлөөлөлтэй байдаг тул нэн түрүүн хөрсийг шатах, тослох материалыар бохирдохогоос хамгаалах, бохирдсон нөхцөлд нэн даруй арга хэмжээ авч байх, ажилчид болон төслийн талбай, түүний нөлөөллийн бүсэд байх талбай дахь ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэх эсэхэд байнга хяналт тавьж ажиллах, гүний худагт усны тоолуур тавьж хэрэглээндээ хяналт тавих зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

#### *Хөрс*

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хөрсний эвдрэлийг аль болох бага байлгах, олон салаа зам гаргахгүй байх, нөхөн сэргээх үйл ажиллагааг цаг алдалгүй хийх, шатах тослох материалыг асгаруулах зэргээр хөрсийг бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлж байх зэрэг орно.

#### *Ургамал*

Ургамлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх, бэлчээрийн эдэлбэр газрын хэмжээг нэмэгдүүлэх (нөхөн сэргээлт), хаврын салхи шуурганы үеэр өнгөн хөрсний алдагдал ихэсдэгийг анхаарч ажлаа зохицуулах, мөн тоос дараах ажиллагааг тогтмол хийж байх, уурхайн үйл ажиллагаанд шууд өртөхгүй газрын ургамлыг хамгаалах зэрэг болно.

#### *Амьтан*

Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль орчны алба, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үед үүсэх дуу чимээний хэмжээг бага түвшинд байлгах, Холбогдох хуулийг нийт ажиллагсдад танилцуулан, уурхайг мал амьтанд аюулгүй байхаар ашиглах шаардлагатай.

### **1.2. Баяжуулах үйлдвэрийн технологи**

#### *1.2.1. Хайлуур жсонийг баяжуулах технологийн сонголт*

Технологийн туршилтад хамрагдсан кварц-флюоритийн анхдагч хүдрийн  $\text{CaF}_2$ -н дундаж агуулга нь 32.0%. Кварцийн агуулга өндөр, флюоритийн мөхлөг жижиг шигтгээлэг тул 2 шатны нунтаглалт /-0.074 мм-ийн ангийн агуулга 97%, 7 шатны цэвэрлэгээ явуулж стандартын шаардлага хангасан баяжмал / $\text{CaF}_2$ -97.29%/ бүтээгдэхүүн гарган авсан. Анхдагч хүдрийн  $\text{CaF}_2$ -н дундаж агуулгыг 50% ба түүнээс бага зэрэг дээш агуулгатайгаар дундажлан авах нь баяжуулалтын хүндрэл багатай байх бөгөөд флотацийн баяжуулалтыг илүү эдийн засгийн үр ашигтай, чанар, авалт өндөр баяжмал бүтээгдэхүүн гаргах боломжтой.

Баяжуулах хүдрийн шинж чанараас хамаарч 2024 оныг хүртэл баяжмалын дундаж агуулга 95.8%тай, баяжмалын металл авалт 78%-тай байна.

*Хүснэгт 1. Технологийн ерөнхий шийдлүүд*

<b>Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал</b>	150 мян.тн/жил 556 тн/хоног 25.72 тн/цаг 270 хоног/жил 6480 цаг/жил
<b>Бутлагдсан хүдрийн ширхэглэл</b>	-12 мм
<b>Анхдагч хүдэр дэх жоншны агуулга</b>	30-40 %
<b>Анхдагч хүдрийн нягт</b>	2.62 гр/см <sup>3</sup>
<b>Хүдэр бэлтгэх процесс</b>	2 шатны бутлалт 1 шатны шигшилт 1 шатны нунтаглалт 1 шатны ангилалт
<b>Хүдэр баяжуулах технологи</b>	Үндсэн флотаци 7 шатны цэвэрлэгээний флотаци 3 шатны хяналтын флотаци
<b>Туслах хэсэг</b>	Өтгөрүүлэх, шүүх, хатаах хэсэг Урвалж найруулах хэсэг Хаягдал хадгалах байгууламж

*1.2.2. Хайлуур жоншины хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн горим*

**Баяжуулах үйлдвэрийн бүтэц**

Баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, нунтаглан баяжуулах хэсэг, баяжмал шүүн хатаах хэсэг, баяжмал савлах, хадгалах хэсэг, хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сан, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, урвалж бодисын агуулах, цахилгаан хангамжийн хэсэг, хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг, ажилчдын байр контор зэргээс бүрдэнэ.

**Хүдэр жигдүүлэлт**

Баяжуулах процесст орж байгаа хүдрийн шинж чанар, хүдэр дэх ашигт болон хорт хольцын агуулгын өөрчлөлт нь үйлдвэрийн хүчин чадал, ажлын горим, баяжмалын чанар, бүтээгдэхүүний гарц, минерал авалт зэрэгт нөлөөлдөг. Ийм учраас баяжуулах үйлдвэрийн технологийн процессыг хэвийн жигд явуулах зорилгоор хүдэр жигдүүлэлтийн ажил хийгддэг.

Жонш олборлогчдоос нийлүүлж буй түүхий эдийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр жигдүүлэх талбайд зөөвөрлөн авчирч, жошны агуулга болон хүдэр дэх карбонатын агуулгаас хамааруулан үечлэн овоолго байгуулах замаар хүдрийг жигдүүлэн баяжуулахад бэлтгэн хадгална. Хүдрийг холих үедээ хүдрийн бүтцийн чанарыг судлах шаардлагатай.

Төслийн үйлдвэрлэлийн баяжуулалтанд орох жоншны хүдэр нь MNS 145:2003 стандартын шаардлага хангасан эрдэс бодисын найрлагатай байна.


**Хүдэр бутлах хэсэг**

Баяжуулах үйлдвэрийн хүдэр бутлах хэсэг нь 2 шатны бутлуур, 1 шатны шигшиүүрээс бүрдэнэ. Анхдагч хүдрийг хяналтын шигшилттэй 2 шатны бутлалтын схемээр буталж хүдрийн ширхэглэлийг -12 мм болгоно.

Анхдагч хүдрийн овоолгоос утгуурт ачигчийн тусламжтай хүдрийг хүлээн авах бункерт өгөх ба бункерын доор суурилагдсан хавтант тэжээгүүр нь нэгдүгээр шатны хацарт бутлуурыг тэжээнэ. Нэгдүгээр шатны хацарт бутлуурын хүлээн авах хүдрийн

хамгийн том ширхэглэл -400 мм байх бөгөөд бутлуураас -80 мм-ийн ширхэглэлтэй хүдэр гарна.

Хяналтын шигшилтийн зорилго нь бутлагдсан хүдрийн ширхэглэлд хяналт тавих болон хоёрдугаар шатны бутлуурт орох шаардлагагүй хүдрийг ялгана. Бутлах цехэд ажиллах шигшүүрийн торны нүхний хэмжээ 15 мм байна. Хяналтын шигшүүрийн торны дээд ангийг (+12 мм-ийн анги) хоёрдугаар шатны бутлуур (1-р шугам хацарт бутлуур, 2-р шугам конусан бутлуур)-т өгөх бөгөөд бутлуураас гарах хүдрийн ширхэглэл -12 мм байна.



Зураг 1. Хүдэр бутлах хэсгийн схем



Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн хүдэр бутлах хэсгийн фото зураг  
Хүдэр нунтаглах хэсэг

Бутлагдсан хүдрийн агуулахаас тээвэрлэгдэн ирэх хүдрийг хяналтын ангилалттай нэг шатны нунтаглалттай схемээр 0.074 мм-ийн ширхэглэлийн ангийн агуулгыг 75%-аас доошгүй болтол нь нунтаглана. Нунтаглалтад MQG2145 маркийн бөмбөлөгт тээрэм ашиглана. Бөмбөлөгт тээрмээс гарсан бүтээгдэхүүнийг FLG-1500 маркийн мушкиа ангилуураар ангилах ба ангилуураас гарах элсийг бөмбөлөгт тээрэмд эргэлтийн ачаалал болгон өгнө.

*Хүснэгт 2. Нунтаглагдсан бүтээгдэхүүний ширхэглэлийн шинжилгээний үр дүн*

№	Ангилал, мм	Эзлэх хэмжээ	
		Жин, гр	Хувь, %
1	-2+1	90	2.2
2	-1+0.315	100	2.4
3	-0.315+0.16	110	2.7
4	-0.16+0.1	132	3.2
5	-0.1+0.074	184	4.5
6	-0.074	308	85
<b>Нийт</b>		<b>924</b>	<b>100</b>



*Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн худэр нунтаглах хэсгийн фото зураг*

### *Худэр баяжуулах хэсэг*

Нунтаглагдсан хүдрийг үндсэн флотациар баяжуулж баяжмалыг 7 үе шатаар цэвэрлэн хаягдлыг 3 шатны хяналтын флотацид оруулна.

Үндсэн флотацийн камериийн бүтээгдэхүүн 1-р шатны хяналтын флотацид орох ба 1-р шатны хяналтын флотацийн хөөсөн бүтээгдэхүүн нь 1-р шатны цэвэрлэгээний флотацийн камериийн бүтээгдэхүүнтэй нийлэн үндсэн флотацид өгөгдөнө. 1-р шатны хяналтын флотацийн камериийн бүтээгдэхүүн 2-р шатны хяналтын флотацид орж түүний хаягдал 3-р шатны хяналтын флотацид орох ба түүний хаягдал хаягдлын аж ахуйд хаягдана. 1-6-р шатны цэвэрлэгээний флотацийн хөөсөн бүтээгдэхүүнүүд нь дараагийн шатны цэвэрлэгээний флотацид өгөгдөх ба 1-7-р шатны цэвэрлэгээний флотацийн камерын бүтээгдэхүүнүүд нь битүү циклээр өмнөх шатны флотацид өгөгдөнө.

*Хүснэгт 3. Флотацийн процессын горимын үзүүлэлтүүд*

№	Параметрүүд	Үзүүлэлтийн утга
1	Флотацийн тэжээл болох материалын хатуугийн агуулга, %	25-32
2	Булингын температур, °C	25-30

3	Флотацийн тэжээлд агуулагдах 0.074мм ангилалын агуулга, %	65
4	Булингын pH орчин	8-9



*Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн нунтаглан баяжуулах хэсгийн фото зураг  
Баяжмал усгүйжүүлэх хэсэг*

VII шатны цэвэрлэгээний флотациас гарах 20-30 %-ийн хатуугийн агуулгатай баяжмалыг NZSG-12 маркийн өтгөрүүлэгчид 50-60 %-ийн хатуугийн агуулгатай болтол өтгөрүүлнэ. Өтгөрсөн баяжмалыг PG27-6 маркийн вакуум фильтрт 8-10 %-ийн чийглэгтэй болтол усгүйжүүлнэ. Шүүлтээс гарах баяжмалыг SZL4 маркийн хатаагуурт хатаана. Хатаалтын дараа баяжмалын чийглэг 0-5% байна.

III шатны хяналтын флотацийн 20-30 %-ийн хатуугийн агуулгатай камерийн бүтээгдэхүүнийг хаягдлын сан руу хаяна. Баяжмалын өтгөрүүлэгч болон шүүлтээс ялгарах усыг баяжуулалтын процесст эргүүлэн ашиглана.



*Зураг 5. Баяжуулах үйлдвэрийн баяжмал усгүйжүүлэх хэсгийн фото зураг  
Баяжмал хатаах хэсэг*

Баяжмалын шүүлтүүрээс гарсан 10-15 хувийн чийгтэй баяжмал 194°C хүртэл хатаах хүрдэн хатаагуурын тэжээл болж 0-5 хувийн чийгтэй баяжмал болно.



*Зураг 6. Баяжмалыг хатаах төхөөрөмжийн фото зураг*

#### **Баяжмал савлах, хадгалах хэсэг**

Хүрдэн хатаагуураас гарсан баяжмалыг тээвэрлэн савлах бункерт оруулна. 2 тонны уутанд баяжмалыг савлан, баяжмал хадгалах агуулахад хадгална. Савлагдсан баяжмалын утан дээр үйлдвэрлэсэн улс, уурхайн нэр, баяжмалын жин, ачигдах орны нэр, хаягийг бичиж тээвэрлэн гадаад зах зээлд гарган борлуулна.

Баяжмалыг худалдах, төмөр замаар тээвэрлэх үед вагоны ачаалал зэргээс хамааран тодорхой хугацаанд хадгалах нөхцөл байдал үүсдэг. Баяжуулах үйлдвэрийн баяжмал хадгалах агуулах нь  $50*80\text{м-ийн}$  хэмжээтэй,  $4000 \text{ м}^2$  талбайтай ба үйлдвэрийн 30-35 хоногт үйлдвэрлэх 5530 тн баяжмалыг хадгалах багтаамжтай байна.



*Зураг 7. Баяжуулах үйлдвэрийн баяжмал савлан хадгалах хэсгийн фото зураг*



Зураг 8. Баяжуулах үйлдвэрийн баяжмал савлан хадгалах хэсгийн фото зураг

### 1.2.3. Жоншины хүдрийг баяжуулах технологийн тооцоо

“Монгол Жү Юань Ли” ХХК-ийн баяжуулах үйлдвэр хайлур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн хүчин чадал 150,000.0 тн/жил байна. Үйлдвэрийн 1 цагт баяжуулах хүдрийн хэмжээ 25.72 тонн байна.

*Хүснэгт 4. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим*

№	Ажиллах горим	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Жилд ажиллах бодит хоног	хоног	270
2	Жилд ажиллах бодит цаг	цаг	6480
3	Хоногт ажиллах бодит цаг	цаг	24
4	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
5	Ээлжинд ажиллах бодит цаг	цаг	12
6	Цагийн хүчин чадал	тн/цаг	25.72
7	Хоногийн хүчин чадал	тн/хон	556
8	Жилийн хүчин чадал	мян.тн/жил	150

### 1.3. Баяжуулах үйлдвэрийн химийн урвалжийн хэрэглээ

Үйлдвэрт хэрэглэх үндсэн урвалжуудын болон ган бөмбөлөгийн зарцуулалтын хэмжээг технологийн туршилтын үр дүнд болон хүдрийн хатуулагт тулгуурлан тогтоосон болно.

*Хүснэгт 5. Баяжуулах үйлдвэрт хэрэглэх урвалжийн хэмжээ*

Үзүүлэлтүүд	Нэгж зарцуулалт, гр/тн	Хэмж их нэгж	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	Нийт
Баяжуулах хүдрийн хэмжээ	-	мян.тн	150.0	150.0	150.0	150.0	150.0	750
Тосны хүчил	800	тн	120.0	120.0	120.0	120.0	120.0	600
Техникийн сод	440	тн	66.0	66.0	66.0	66.0	66.0	330
Шингэн шил	520	тн	78.0	78.0	78.0	78.0	78.0	390
Хөнгөнцагааны сульфат	1000	тн	150.0	150.0	150.0	150.0	150.0	750

#### Техникийн сод ( $Na_2CO_3$ )

Техникийн сод нь шүлтлэг орчныг тохируулагч, шаардлагатай pH бүрдүүлдэг, усанд сайн уусдаг. 1%-ийн содын уусмал pH=11 хүртэл орчинг бүрдүүлнэ. 5%-ийн содын уусмалыг тээрэмд өгнө. Сод болон шингэн шилний шүлтлэг урвалжийг флотацид хэрэглэнээр хөвүүлэн баяжуулах процесс нь шүлтлэг орчинд явагдана. Шүлтлэг орчинд хөөсрөлт сайн бүрэлддэг.

*Хүснэгт 6. Техникийн сод ( $Na_2CO_3$ )-ийн норм, шаардлага*

№	Үзүүлэлтүүд	Норм	
		Сорт 1	Сорт 2
1	Гадаад байдал	Нунтаг цагаан өнгөтэй бодис	
2	$Na_2CO_3$ агуулагдах хэмжээ, %, багагүй	99.2	99.0
3	Хлоридын агуулга, %, ихгүй	0.5	0.8
4	$Fe_2O_3$ тооцсон төмрийн агуулга, %, ихгүй	0.003	0.008
5	Усанд үл уусах бодис, %, ихгүй	0.04	0.08
6	$Na_2SO_3$ тооцсон сульфатын агуулга, %, ихгүй	0.05	Нормгүй
7	Хувийн жин, тн/м <sup>3</sup>	2.48	2.48

### Шингэн шил ( $Na_2SiO_3$ )

Шингэн шил нь бага зэрэг ногоон, шар түяатай тунгалаг хатуу бодис юм. Натрийн силикатыг үйлдвэрийн нөхцөлд  $1300-1500^{\circ}\text{C}$  температурт элсэн чулууг хайлувж гарган авдаг. Задгай саванд байгаа шингэн шилний уусмал нь тогтворжилт муутай байдаг. Уусмалын концентраци нь 5%-иас хэтрэх ёсгүй. Шингэн шил нь хөвүүлэн баяжуулалтанд кварц, силикат болон хоосон чулуулгийг дарах зориулалттай хэрэглэгддэг.

Хүснэгт 7. Шингэн шил буюу силикат натрийн шаардлага

№	Үзүүлэлт	Шаардагдах норм	
		Содын	Сульфат содын
1	Гадаад хэлбэр	Жигд, тунгалаг, хэлбэр дурсгүй	
		Ногоовтор ба цэнхэр түяатай	Хар ногоон ба хүрэн
2	SiO <sub>2</sub> -н агуулга, % -аас игүй	70.8-76.2	69.7-72.4
3	Кальцийн исэл, % ихгүй	0.4	0.5
4	Хүхрийн ангидрид, % ихгүй	0.3	1.25
5	Натрийн исэл, %	22.5-27.9	24.9-27.5
6	Силикатын модуль	2.61-3.5	2.61-3.0
7	Хувийн жин, тн/м <sup>3</sup>	2.7	2.7

### Тосны хүчил ( $C_{17}H_{33}COOH$ )

Тосны хүчлийг найруулахдаа холих танкны 2/3-т ус хийж холигч сэнсийг эргүүлж халуун уураар халаахын зэрэгцээ 240 кг буюу 6 уут содыг хийж 2 цагийн турш уусгалтыг явуулна. Уусмалыг  $70-80^{\circ}\text{C}$  хүртэл халаана. Содыг уусгасны дараа 1.4 м<sup>3</sup> тосны хүчлийг танканд хийнэ. Холих танкыг усаар дүүргэн  $70-80^{\circ}\text{C}$  –ийн температурт 2-3 цагийн хугацаагаар уусгах ажиллагаа явуулна. Үүний дараа уусмалаас дээж авч концентрацийг тодорхойлно. Уусмалын концентраци 1.5% байна.

### Хөнгөнцагааны сульфат ( $Al_2(SO_4)_3 \cdot 7H_2O$ )<sub>n</sub>

Хөнгөнцагааны сульфат нь зунгааралдсан шинж чанартай, хурц үнэртэй, шаравтар түяатай тунгалаг бодис юм.

Булинга дахь тунадасыг барьцалдуулах идэвх сайтай бодис юм. Өтгөрүүлэх процесст идэвх сайтай.

#### 1.4. Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж

Тус баяжуулах үйлдвэр нь 2014 оноос барилга угсралтын ажил эхлэж 2015 онд ашиглалтад орсон ба үйлдвэрт ажиллаж буй тоног төхөөмжийн элэгдлийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-д заасны дагуу шулуун шугамын аргаар тооцож байна.

Хүснэгт 8. Тоног төхөөрөмжийн наслжилт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Ашигладтанд орсон он	Ашиглалтын хугацаа
1	Чичиргээт тэжээгүүр	Y47100200	2015	5
2	Хацарт бутлуур	PE600x900	2015	5
3	Туузан дамжуулагч	BK-800	2015	5

4	Конусан бутлуур	PFL-1750A	2015	5
5	Туузан дамжуулагч	BK-1000	2015	5
6	Чичиргээт шигшүүр	SZZ22142	2015	5
7	Чичиргээт тэжээгүүр	600x600	2015	5
8	Гидроциклон	ХС-II-Ф350	2015	5
9	Бөмбөлөгт тээрэм	Φ2400x6000	2015	5
10	Мушгия ангилуур	BJ-3000x3000	2015	5
11	Бөмбөлөгт тээрэм	Φ2100x4500	2015	5
12	Флотомашин	SF-1.2	2015	5
13	Флотомашин	SF-2.8	2015	5
14	Булингын насос	125	2015	5
15	Булингын насос	30	2015	5
16	Баяжмал өтгөрүүлэгч	NZ-15	2015	5
17	Баяжмалын шүүлтүүр	GP48-4	2015	5
18	Хатаагуур	SZL4-1.25	2017	3
19	Өргөгч кран	LDA-3	2014	6
20	Цахилгаан кран	LDA-10	2014	6
21	Цахилгаан кран	LDA-5	2014	6

## 1.5. Төслийн барилга байгууламж, дэд бүтэц

### 1.5.1. Төслийн усан хангамж

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутаг дахь “Хайлуур жонш” нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах болон хайлуур жоншийг хүдрийг флотацийн аргаар баяжуулах үйлдвэрт ашиглагдах усны боломжит нөөцийн дүгнэлтийг 2018 онд “Монгол Ус” ТӨААТҮҮГ-аас гаргасан ба уг дүгнэлтэд тус ордын талбайд байрлах 3 худгаас нийт уурхай үйлдвэрийн усны хэрэгцээг бүрэн хангах боломжтой гэж дүгнэжээ.

Баяжуулах үйлдвэрийн технологийн болон ажилчдын ахуйн хэрэглээний усыг өөрийн талбайд байрлах дараах 3 худгаас хангадаг. Худгаас баяжуулах үйлдвэрийн дэргэд байгуулагдсан технологийн цэвэр усны санд хуримтлуулан тэндээс үйлдвэрийн хэрэгцээний усыг насосын тусламжтайгаар үйлдвэрийг тэжээнэ.

#### 1-р худгийн байршилийн координат:

Өргөрөг: 47° 33' 38.10"

Уртраг: 112° 09' 16.50"

Үнэмлэхүй өндөр: 1103

Худгийн гүн: 150 метр

Худгийн ундарга: 10.0 л/с

#### 2-р худгийн байршилийн координат:

Өргөрөг: 47° 33' 38.20"

Уртраг: 112° 09' 16.60"

Үнэмлэхүй өндөр: 1107

Худгийн гүн: 160 метр

Худгийн ундарга: 2.0 л/с

*3-р худгийн байришилийн координат:*

Өргөрөг:  $47^{\circ} 33' 38.80''$

Үртраг:  $112^{\circ} 09' 12.60''$

Үнэмлэхүй өндөр: 1112

Худгийн гүн: 130 метр

Худгийн ундарга: 2.0 л/с



*Зураг 9. Төслийн талбайд байрлах худгуудын байришил  
Баяжуулах үйлдвэрийн усан хангамж*

Үйлдвэрт хэрэглэх усыг зориулалтаар нь технологийн, техникийн, унд-ахуйн ус, бусад хэрэглээний ус гэж ялгаж тооцоолон, үйлдвэрт нийтэд нь шаардлагатай усны хэмжээг тооцоолсон болно. Үйлдвэрийн технологийн усны хэрэгцээ цагт дунджаар  $102.4 \text{ m}^3$  түүхий ус шаардлагатайг үйлдвэрийн усны балансын тооцоогоор тогтоосон ба баяжуулах үйлдвэр нь ашиглагдсан усныхаа **77.8%-ийг** эргүүлэн ашиглах ба үйлдвэрийн цэвэр усны хэрэгцээ хоногт  $431.66 \text{ m}^3$  байна. Уг хэрэгцээг төслийн талбайд байрлах 10.0 л/с, 2.0 л/с, 2.0 л/с ундарга бүхий 3 худгаас хангана.

Хүснэгт 9. Технологийн усны хэрэглээ

№	Үзүүлэлт	Норм	Баяжуулах бүтээгдэхүүний хэмжээ, тн		Нийт ашиглах усны хэмжээ, м <sup>3</sup>		Эргэлтийн системээр дахин ашиглах усны хэмжээ, м <sup>3</sup>		Нэмэлтээр ашиглах цэвэр усны хэмжээ, м <sup>3</sup>		Баримтлах стандарт
			хоног	жил	хоног	жил	хоног	жил	хоног	жил	
1	Жонш баяжуулах үйлдвэр	3.5 тонн	556.0	52000	1944.4	182000	1512.74	144300	431.66	40040	A/301 дугаар тушаалын 2-р хавсралт

Ахуйн хэрэгцээний тооцоо

Нэг хүний хоногийн ахуйн хэрэгцээний ус 150 л байх ба энэ нь усны хэрэглээний хамгийн их байх үеийн тооцоо болно.

Уурхайн хотхонд нэг дор байрлах ажилчдын тоо нь уурхайн үйлдвэрийн ажилчид болон удирдах албан тушаалтанууд нийтдээ 88 хүн байрлан ажиллахаар тусгасан. Ахуйн хэрэглээний хоногийн усны хэмжээ нийт 13.2 м<sup>3</sup> байх тооцоотой байна.

Хүснэгт 10. Ахуйн хэрэглээний усны тооцоо

№	Үзүүлэлт	Хоногийн усны хэрэглээ, м <sup>3</sup>	Жилийн усны хэрэглээ, м <sup>3</sup>	Усны эх үүсэр, ундарга
1	Үнд, ахуйн хэрэглээний ус, хоногт 20 л/хүн	13.2	3564.0	2.0 л/с/гүний худаг/
-	Нийт дүн	13.2	3564.0	-

1.6.1. Баяжуулах үйлдвэрийн лаборатори

Баяжуулах үйлдвэрийн дэргэд хяналт, шинжилгээний лаборатори байрлана. Хяналтын лаборатори нь баяжуулах үйлдвэрт уурхайнуудаас ирж буй хүдрийн агуулгийг дундажлан жигдриүүлэх зорилгоор ашигт болон хорт хольцын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэлийн процесст хяналт тавьж хэвийн ажиллагааг хангах, технологийн зааврын дагуу үйлдвэрийн дамжлагуудын үйл ажиллагааг хянах, үйлдвэрийн технологийн дээжийг шинжлэх, бүтээгдэхүүний чанарт иж бүрэн шинжилгээ судалгаа хийх зорилготой.

Анхдагч хүдэр, баяжмал ба хаягдаас 6 цаг тутамд дээж аван ашигт эрдсийн болон хорт хольцын агуулгыг тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд хуваариас гадна тухай бүрт нь шинжилгээ хийж үйлдвэрийн доголдлыг илрүүлж тохиргоо хийн технологийг удирдан тогтвортой үйл ажиллагааг явуулна.

Мөн анхдагч хүдэр, баяжмал болон хаягдал хүдрийн технологийн болон химийн шинж чанарыг судалж, үйлдвэрлэлийн технологийг шинэчилж өөрчлөхөд удирдамж болгохын тулд тогтмол хугацаагаар үйлдвэрлэлийн бүх горим, дамжлагад химийн шинжилгээ хийж дүгнэлт гаргана. Үйлдвэрийн технологийн эргэлтийн усыг ээлж бүр нэг удаа тогтмол шалгаж, усанд агуулагдах элементүүдийг зөвшөөрөгдөх стандартын дагуу мөрдөн, хянаж ажиллана. Үүнээс гадна процесийн дамжлага бүр дээрх

үзүүлэлтийг хянаж ажилласнаар үүсэж болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлж баяжуулах үйлдвэрийн сүл зогсолтыг бууруулна.

Хяналтын лаборатори нь аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн дүрэм журмуудыг хангаж ажиллахаас гадна ХАЛМ (Хор аюулын лавлах материал) болон САЖ (Стандарт ажлын журам)-ийг мөрдөн дараах ажлыг гүйцэтгэнэ.

Дээж бэлтгэл

Флотацийн туршилт

Ширхэглэлийн шинжилгээ

Баяжмал, хаягдлын чийглэг, хатуу шингэний харьцааг тодорхойлох

Нунтаглалтын хугацааг тодорхойлох

Химийн шинжилгээ – CaF<sub>2</sub>, CaCO<sub>3</sub>, SiO<sub>2</sub>, S, P<sub>2</sub>, O<sub>2</sub> ба бусад элементүүдийг ээлжийн лаборантууд 24 цагт шинжилгээ хийж үзүүлэлтүүдээ тодорхойлно.

*Хүснэгт 11. Лабораторийн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт*

№	Төхөөрөмжийн нэр	Марк	Хүчин чадал
1	Аналитик жин	FA2104A	0.0001-160 гр
2	Техник жин	BFW 150	150 кг хүртэл
3	Бөмбөлөгт жижиг тээрэм	HF серийн	-
4	РН метр	PHS-25	РН-0-14
5	Микроскоп	TXS102-01A	томруулалт 100x-1250x
6	Ус нэрэгч	HS.Z11.5	5 литр
7	Центрифуги	TGL-165	16500 эрг/мин 12x1.5/2ml
8	Хатаах шүүгээ	DZ 6050MBE	
9	Шатаах зуух	ST-1200RX	Ажлын температур 11000 С
10	Лабораторийн ширээ	JTM-S13	
11	Термометр	H-9283	
12	Хуваагч	TX	Хуваах хэмжээ 1.25-13 мм
13	Спектрометр	722G	Долгионы уртын хязгаар 325-1000 nm
14	Лабораторийн жижиг багаж, шил сав, бусад	-	-
15	Хацарт бутлуур, булт бутлуурын комплекс	HF серийн	-
16	Вентилятор	-	-
17	Хөрс, ус, агаарын бохирдлыг хянах шинжилгээний багаж	-	-
18	Бусад тоног төхөөрөмж, багаж	-	-

Лаборатори нь дээж шинжилгээнд бутлан бэлтгэх тоног төхөөрөмжүүдээс гадна аналитик жин, хатаах шүүгээ, шатаах зуух, калориметр, стандарт шигшүүр, химийн шилэн савууд зэрэг техник тоног тохөөрөмж бүрэн тоноглогдоно. Лабораторит CaF<sub>2</sub>, CaCO<sub>3</sub>, SO<sub>2</sub>, SO<sub>3</sub>, P<sub>2</sub>, O<sub>2</sub>, S ба бусад элементүүдийг ээлжийн лаборантууд 24 цагт шинжилгээ хийж үзүүлэлтүүдээ тодорхойлно.

Баяжуулах үйлдвэрийн химийн лабораторит флюоритын баяжмал, товарын бүтээгдэхүүн гаргаж авах технологийн процессод хяналт тавьж экспресс шинжилгээ хийх. Технологийн процессод хэрэглэх урвалын шинж чанарт хяналт тавих ажлуудыг дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Мөн лабораторийн хэрэглээнд дараахи химийн бодисуудыыг ашиглана. Химийн бодисуудын нэршил болон хэрэглээг хүснэгтээр үзүүллээ.

*Хүснэгт 12. Баяжуулах үйлдвэрийн химийн лабораторт ашиглагдах химийн бодисын нэршил ба хэрэглээ*

Химийн томъёо	Олон улсын иэршил	Монгол иэршил	Савалга, мл, гр	Нийт хэрэглэгдэх хэмжээ, ш
HCl	Hydrochloric acid	Давсны хүчил	500ml	300
H <sub>2</sub> SO <sub>4</sub>	Sulfuric acid	Хүхрийн хүчин	500ml	6
C <sub>2</sub> H <sub>6</sub> O	Ethyl alcohol absolute	Хуурай этанол	500ml	120
C <sub>6</sub> H <sub>15</sub> NO <sub>3</sub>	Trolamineб. TEA	Триетаноламин	500ml	60
CH <sub>3</sub> COOH	Aceticacid	Цууны хүчил	500g	60
H <sub>3</sub> BO <sub>3</sub>	Orthoboric acid	Боорын хүчил	500g	180
KOH	Poptassium hydroxide	Калийн гидроксид	500g	300
C <sub>2</sub> H <sub>8</sub> N <sub>2</sub>	Ethylenediamine	Этиленеидионин	500g	30
FH	Hydrofluoric acid	Уусмалын хүчил /плавиковач кислота/	500ml	30
C <sub>6</sub> H <sub>8</sub> O <sub>6</sub>	Vitamin C, Ascorbic asid	Аскорбины хүчил	25g	12
HONH <sub>3</sub> C	Hydroxylamine hydrochloride	Гидроксилямин гидрохлорид	25g	12
C <sub>30</sub> H <sub>26</sub> N <sub>2</sub> O <sub>13</sub>	Calcein	Кальциен	5g	60
C <sub>28</sub> H <sub>30</sub> O <sub>4</sub>	Thymolphthalein	Тимолфталеин	25	30
KI	Potassium iodide	Калийн иодид	100g	2
KIO <sub>3</sub>	Potassium iodade	Калийн иодат	100g	2
(C <sub>6</sub> H <sub>10</sub> O <sub>5</sub> )n	Amylum	Цардуул	500g	2
HBr	Hydrobromic acid	Гидробромийн хүчил	500ml	6
HClO <sub>4</sub>	Perchloric acid	Перхлорын хүчил	500ml	6
NaCl	sodium chloride	Хуурай натрийн хлорид /безводный хлорид натрия/	500g	12
H <sub>8</sub> MoN <sub>2</sub> O <sub>4</sub>	Ammonium molybdate	Аммонийн молибдат	500g	2
K <sub>2</sub> SO <sub>4</sub>	Potassium sulphate	Хуурай калийн сульфат /безводный сульфат калия/	500g	3
KH <sub>2</sub> PO <sub>4</sub>	Potassium phosphate monobasic	Калийн дигодрофосфат	100g	2

Лаборатори нь үйлдвэрт тэжээх анхдагч хүдрийн шинж чанараас эхлээд бүхий л шат дамжлагуудад шаардлагатай үед шинжилгээ судалгаа туршилт явуулан хяналт тавьж, үйлдвэрийн технологийн процессыг сайжруулж гарц, металл авалт, агуулга зэргийг хамгийн өндөр байлгах зорилт тавин ажиллах ба технологийн горимыг хянан тохируулна.

#### ***Лабораторийн хийгдэх үндсэн ажил, хяналт***

Лаборатори нь үйлдвэрт тэжээх анхдагч хүдрийн шинж чанараас эхлээд бүхий л шат дамжлагуудад шаардлагатай үед шинжилгээ судалгаа туршилт явуулан хяналт тавьж, үйлдвэрийн технологийн процессыг сайжруулж гарц, металл авалт, агуулга зэргийг хамгийн өндөр байлгах зорилт тавин ажиллах ба технологийн горимыг хянан тохируулна.

#### ***Технологийн горимын мөрдөлтөөр:***

Анхдагч хүдрийн агуулга, шинж чанар хорт хольц  
Флотацийн пульпын температур, зарцуулалт  
Баяжмал бүтээгдэхүүний чанарын хяналт  
Тээрэмд нунтаглагдсан хүдрийн ширхгийн хэмжээ Урвалж бодисын чанар  
Эргэлтийн усны шинж чанар найрлага  
Хаягдал хүдрийг хянах

Баяжуулалтын технологийн дамжлага бэлэн бүтээгдэхүүн баяжмалын чанарт байнгын хяналт тавих дараахи стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.

#### Лабораторийн мөрдөж ажиллах стандартууд

- Лабораторийн шинжилгээний дээж авах ба түүнийг бэлтгэх. MCS 2205-83
- Химийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага. MCS 2699-86
- Хайлуур жонш. Чийгийн агуулгыг тодорхойлох арга. MHS 2700-86
- Хайлуур жонш. Гуравч ислийг тодорхойлох арга. MHS 2704-86
- Хайлуур жонш. Төмрийн агуулгыг тодорхойлох арга. MHS 2705-86
- Хайлуур жонш. Сульфид хүдрийн агуулгыг тодорхойлох арга. MMS 2703-86
- Хайлуур жонш. Хүхрийн нийт хэмжээг тодорхойлох арга. MMS 2706-86
- Хайлуур жонш дахь нүүрсхүчлийн калыди болон фосфорт кальцийг тодорхойлох арга. MHS 4928-2000
- Хайлуур жоншны баяжмал, окатыш болон брикет дэх нүүрсхүчлийн калыди, фосфорт кальци, цахиурын хоёрч исэл, фосфор болон нийт хүхрийг тодорхойлох арга. MHS 4929- 2000
- Хайлуур жоншны баяжмалын техникийн шаардлага . MHS 145-2003

#### 1.6.2. Хаягдлын аж ахуй

Хаягдлын аж ахуй нь жонш баяжуулах үйлдвэрээс хойд зүгт 350 м зайд байрлана. Баяжуулах үйлдвэрийн үндсэн дамжлагын нэг нь хаягдлын аж ахуй юм. Баяжуулах үйлдвэрээс гарч буй хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр байршуулах нь чухал ач холбогдолтой. Хаягдлын тээвэрлэлт, хаягдлын сангийн тоног төхөөрөмжийн барилга байгууламж, эргэлтийн усан сангийн хангамж нь бүхэлдээ хаягдлын аж ахуйд хамаарна. Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйн зураг төслийг “Усны эрчим” ХХК-аар, геотехникийн судалгааг “Таван үндэс” ХХК-иар тус тус гүйцэтгүүлэн, барьж байгуулсан байна. Далан нь 3 хэсгээс бүрдэх ба сан 1 нь 35850 м<sup>2</sup>, 3.5 м-ийн гүнтэй 125475 м<sup>3</sup> бүхий багтаамжтай, сан 2 нь 31400 м<sup>2</sup>, 3.5 м-ийн гүнтэй 109900 м<sup>3</sup>, сан 3 нь 6250 м<sup>2</sup>, 4 м-ийн гүнтэй 25000 м<sup>3</sup> тус тус багтаамжтай. 2024-2026 онуудад хуримтлагдах хаягдлыг бүрэн багтаахаар байна.



*Зураг 10. Хаягдлын сангийн зураг*

Баяжуулах үйлдвэр ба хаягдлын сангийн хооронд хоёр шугам хоолой байх ба нэг хоолойгоор хаягдлыг сан руу шахаж нөгөөгөөр нь эргэлтийн усыг үйлдвэр лүү буцаан шахна. Хаягдлын санд хөвөх насосны систем байрлуулсан.

Хаягдлын сан нь хойноосоо урагш чиглэлд 0.25 км, зүүнээс баруун тийш 0.2 км гүн нь 2-4 м хэмжээтэй байна.

Хаягдлын даланг байгуулахдаа дараах нөхцөлүүдийг харгалзан авч үзсэн. Үүнд:

Ашиглалтын нийт хугацаанд гарах хаягдлыг багтаах хангалттай багтаамжтай байх  
Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх

Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах

Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх

Хаягдлаас шүүрсэн ус гүний усанд нэвчихгүй байх нөхцлийг хангах, нэвчилтийг хянах боломжтой байх

Хаягдал тээвэрлэх зардлыг хамгийн бага байлгах

Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх

#### 1.6.3. Захиргааны ба ахуйн барилга байгууламж

